



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1365
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Г.ВАНДАНЖУШ
ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн Гомбосүрэнгийн Ванданжүшийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Гомбосүрэнгийн Ванданжүшийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн


Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Гомбосүрэнгийн Ванданжүшийн мөрийн хөтөлбөр / 2 ... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 ... хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР




**НИТХ-ЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Бие даан нэр дэвшигч: Г.Ванданжүш

НИТХ-д бие даагчдын төлөөлөл сонгогдон орсноор эрх баригчдыг бодитоор хянах, иргэний төлөөлөл болон ажиллах нөхцөл бүрдэнэ. Иймийн тулд дараах мөрийн хөтөлбөрийг боловсруулан сонгогчдод толилуулж байна.

1. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд иргэний төлөөлөл болон ажиллана.
2. НИТХ болон Нийслэлийн засаг дарга, түүний ажлын албанд хяналт тавьж ажиллана.
3. Нийслэлийн иргэдийн санал гомдол, хүсэлтийг төрд илгээх, түүний биелэлт, хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.
4. Нийслэлийн төсөв хуваарилалт, түүний зарцуулалтад хяналт тавьж, үргүй зардлыг бууруулах, төсвийн зохисгүй хуваарилалтыг илчлэх иргэний хяналтын үүргийг гүйцэтгэнэ.
5. Нийслэлийн төсвийн захиран зарцуулалтад шилэн дансны ил тод байдлыг хангуулах ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.
6. Нийслэлээс зарлаж буй тендер, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт тавих, тендер шалгаруулалтыг шударга, оновчтой байлгах үндсэн нөхцлийг бүрдүүлнэ.
7. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ, түүнийг чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.
8. Иргэд, оршин суугчдын эрх ашгийг зөрчсөн, нийтийн эзэмшлийн талбайд халдан барилга байгууламж барьж буй аливаа зөрчилд иргэний дуу хоолой болон ажиллаж, хууль зөрчсөн, шударга бус шийдвэрүүдийг цуцлуулан ажиллахад манлайлан ажиллана.
9. Нийслэлийн ИТХ болон Засаг даргын гаргаж буй иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндөхтэй холбоотой аливаа шийдвэрт олон нийт, нийслэлийн оршин суугчдын санал бодлыг тусгуулах тал дээр санаачилгатай ажиллана.
10. НИТХ-ын төлөөлөгчийн хувьд иргэдийн гомдол саналыг хүлээн авч уламжлах цахим системийг боловсруулж, ажиллуулах тал дээр санаачилга ажиллана.
11. Нийслэлийн төрийн болон үйлчилгээний албанд улс төрийн болон хамаатан садны томилгоо хийдэг тогтолцоог халах чиглэлд хяналттай ажиллаж, мерит зарчмаар томилогддог, төрийн албаны залгамж холбоог хамгаалах чиглэлд ажиллана.
12. Улс төрийн томилгооны золиос болон ажлаас халагдсан төрийн болон үйлчилгээний албан хаагчдын судалгаа хийж, тэднийг буцаан томилуулах, хуулийн дагуу нөхөн олговор олгуулах ажлыг хариуцан зохион байгуулна.
13. Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын дарга нарын тансаглалыг зогсоох, хот дотор том оврын үнэтэй машин унадаг байдлыг арилгахад санаачилга гарган ажиллана.
14. Төсвийн хөрөнгөөр гадаад дотоодод амарч зугаалдаг байдлыг илрүүлэн нийтэд мэдээлж, ийм зохисгүй байдлыг арилгах чиглэлд санаачилгатай ажиллана.



15. Төрийн байгууллагын зарим чиг үүргийн нийслэлийн хэмжээнд мэргэжлийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх боломжийг судлан, танилцуулж шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлнэ.
16. Нийслэлд хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн эрэмбийг зөв гаргаж, ашиггүй, хойшлуулж болох төсөл хөтөлбөрийн жагсаалт гарган, зайлшгүй санхүүжүүлэх нэн шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэргүүн ээлжид санхүүжүүлэх эрэмбийн судалгааг гарган шийдвэрлүүлэх ажлын хариуцан ажиллана.
17. Нийслэлд хэрэгжиж байгаа олон улсын зээл тусламжийн төслүүдэд хяналт тавьж, тухайн төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсөл хоорондын болон төр, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах тал дээр санаачилгатай ажиллана.
18. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн чанарт хяналт тавьж, нийтэд мэдээлж, сайжруулах чиглэлд дэмжин ажиллана.

